

Агуулга

4

МЭНДЧИЛГЭЭ

6

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО

8

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД:

8

Премиум корпорэйшний хөрөнгө оруулалтын багцад нэгдэв

8

Премиум корпорэйшний нийт ажиллагсдад зориулсан
“Цалингийн зээл”-ийн бүтээгдэхүүн нэвтрүүллээ

9

Ханган нийлүүлэгчдэд зориулсан зээлийн
бүтээгдэхүүн нэвтрүүллээ

9

Төгс бүтээгч үйл ажиллагаанд оролцлоо

9

“УБ МАРАФОН-2024”-д оролцлоо

10

ISO/IEC 27001:2022 стандартыг нэвтрүүллээ

10

Шинэ салбарууд нээгдлээ

11

Веер апп-ыг зах зээлд нэвтрүүллээ

11

Барьцаат зээлийн судалгаа онлайн боллоо

12

БҮТЭЭГДЭХҮҮН

14

ХҮНИЙ НӨӨЦ

15

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

16

Аудитын тайлан

18

Эрсдэлийн удирдлага

20

Засаглал

22

ТУЗ-ын бүрэлдэхүүн

26

Хувьцаа эзэмшигчдын хурал

28

Байгууллагын бүтэц



Бүтээ, ирээдүйг эзэгнэ ...
Санхүүжүүлье!



Мэндчилгээ

ЭРХЭМ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ХАМТРАН АЖИЛЛАГЧ
БАЙГУУЛЛАГА, ХАРИЛЦАГЧ ТА БҮХЭНД ЭНЭ ӨДРИЙН
МЭНДИЙГ ХҮРГЭЭ.

Гүйцэтгэх захирал Л.ЦОЛМОН



“Финко Капитал ББСБ”

ХХК нь 2005 онд үүсгэн байгуулагдсан ба дэлхийн жишигт нийцсэн чанар, инновацийг нэвтрүүлэн хамгийн шинэлэг, шилдэг, мэргэжлийн санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэдээ түргэн шуурхай хүргэх эрхэм зорилготойгоор үүсгэн байгуулагдсан санхүүгийн ууган компаниудын нэг юм.

2024 онд бидний хувьд бүтэц зохион байгуулалтаа шинэчлэн харилцагчид хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах чиглэлд түлхүү анхаарч ажилласан жил боллоо.

Үүний хүрээнд хамтран ажиллагч байгууллага болон харилцагчдынхаа мэдээллийн аюулгүй байдал, үйл ажиллагааны цогц байдлыг найдвартай хангах Мэдээллийн Аюулгүй Байдлын Удирдлагын Тогтолцоог /МАБУТ/ амжилттай нэвтрүүлж, ISO27001:2022 олон улсын стандартын батламжийг хүлээн авлаа.

Мөн харилцагч бүрд хүрч ажиллах, үйлчилгээнийхээ хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Да Хүрээ Авто Худалдааны Төв болон 22 Авто Худалдааны Төвүүдэд салбараа нээж нийт 3 салбартайгаар үйл ажиллагаагаа өргөжүүлснээс гадна 24/7 цагт хүссэн газраасаа цахим зээл авах болон барьцаат зээлийн хүсэлтийг цахимаар судлуулах боломжийг бүрдүүлсэн Финтек зээлийн үйлчилгээгээ нэвтрүүлж ажиллалаа.

Цаашид шинэлэг шийдэл бүхий инноваци шингэсэн технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

Харилцагч, хамтран ажиллагч, хөрөнгө оруулагч та бүхнийхээ ИРЭЭДҮЙГ ЭЗЭГНЭ-х замын их БҮТЭЭ-н байгуулалтын үнэнч САНХҮҮЖҮҮЛЭГЧ тань болж ажиллахдаа үргэлж таатай байх болно.

Алсын хараа,



АЛСЫН ХАРАА

БИД ОРЧИН ҮЕИЙН УДИРДЛАГЫН АРГА БАРИЛ, ЧАДВАРЛАГ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХОСЛУУЛАН ӨНДӨР ТҮВШНИЙ, МЭРГЭЖЛИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭГЧ КОМПАНИ БАЙНА.



ЭРХЭМ ЗОРИЛГО

ДЭЛХИЙН ЖИШИГТ НИЙЦСЭН ЧАНАР, ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЭН ХАМГИЙН ШИНЭЛЭГ, ШИЛДЭГ МЭРГЭЖЛИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЛЭГЧДЭДЭЭ ТҮРГЭН ШУУРХАЙ ХҮРГЭЖ, ХЭРЭГЛЭГЧДИЙНХЭЭ НОМЕР НЭГ СОНГОЛТ БАЙНА.

Эрхэм зорилго

Үнэт зүйлс

- Үнэнч шударга байдал
- Тэгш эрх
- Шинэлэг санаа, шилдэг шийдэл
- Ил тод нээлттэй байдал
- Нэгдмэл, хүчирхэг баг
- Тасралтгүй суралцах процесс

Баримтлах зарчим

Бид хуулийг дээдэлж МУ-ын хууль тогтоомж, Финко Капитал ББСБ-ийн Ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллана.

Бид ажилтан, түнш, хэрэглэгчтэйгээ харилцахдаа үнэнч шударга зарчмыг баримтална.

Мэргэшсэн, хариуцлагатай, өндөр ур чадвартай, өөрийгөө болон бусдыг хөгжүүлдэг хамт олныг бүрдүүлнэ.

Бид үйл ажиллагаандаа нээлттэй, шударга, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

Бид ажилтан бүрд хөгжиж, ахиж дэвших орчныг бүрдүүлж, ижил тэгш бололцоо олгоно.

Бид нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэнэ.

2024 оны онцлох үйл явдлууд



• ПРЕМИУМ КОРПОРЕЙШНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦАД НЭГДЭВ

Премиум корпорэйшн (Премиум) нь өндөр өсөлттэй салбаруудад зах зээлийн тэргүүлэгч бизнесүүдээс бүрдсэн хөрөнгө оруулалтын багцыг удирдаж буй мэргэшсэн хөрөнгө оруулалтын компани юм. Премиум нь бизнесийн бодит үнэ цэнийг бий болгох, олон улсын капитал, нөү хау, технологитой холбогдох хүрээлэл, тогтвортой бизнесийн өндөр өсөлтийг ханган ажиллах олон жилийн туршлага дээрээ тулгуурлан хөрөнгө оруулалт хийж буй компани бүрийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн төлөө ажилладаг.

• ПРЕМИУМ КОРПОРЕЙШНИЙ НИЙТ АЖИЛЛАГСДАД ЗОРИУЛСАН “ЦАЛИНГИЙН ЗЭЭЛ”-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН НЭВТРҮҮЛЛЭЭ

Премиум корпорэйшний харъяа компаниудын ажилтнуудад зориулж тусгай нөхцөлтэй “Цалингийн зээл”-ийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлэн 350 гаруй ажилтнуудад танилцуулга өдөрлөгийг амжилттай зохион байгуулав. Цаашид ч группын харъяа ажилтнуудад зориулсан тусгай нөхцөлтэй бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.



• ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДЭД
ЗОРИУЛСАН ЗЭЭЛИЙН
БҮТЭЭГДЭХҮҮН
НЭВТРҮҮЛЛЭЭ

Премиум Корпорэйшн компанийн ханган нийлүүлэгчдэд зориулсан тусгай нөхцөлтэй зээлийн бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүллээ. Ингэснээр Ханган нийлүүлэгч нь нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээнийхээ төлбөрийг орж ирэх хүртэл хугацаанд дараагийн татан авалт хийх, үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлэх зэрэгт үүссэн бэлэн мөнгөний хэрэгцээгээ түргэн шуурхай шийдвэрлүүлэх бүрэн боломжтой болж байна.

• ТӨГС БҮТЭЭГЧ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ОРОЛЦЛОО

Жил бүр Премиум Корпорэйшний санаачлан зохион байгуулдаг "Төгс бүтээгч" арга хэмжээнд барилгын салбарын бизнес эрхлэгч, туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчидэд зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулж, Премиум Буйлдинг Материалс ХХК-тай хамтран гаргасан "Хүү хуваах тусгай нөхцөлтэй бетон зуурмагийн зээл"-н бүтээгдэхүүнээ онцоллоо.

• "УБ МАРАФОН-2024"-Д
ОРОЛЦЛОО

Эрүүл, зөв амьдралын хэв маягийг эрхэмлэн хамт олноороо "УБ Марафон-2024"-д оролцож нэгэн өдрийг халуун дулаан уур амьсгалтай, эрч хүчээр дүүрэн өнгөрүүллээ. Цаашид жил бүрэн байгууллага хамт олноороо УБ Марафон-д тогтмол оролцдог болохоор зорьж байна.



2024 оны онцлох үйл явдлууд



• ISO/IEC 27001:2022

СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЛЭЭ

Хамтран ажиллагч албан байгууллага болон харилцагчдынхаа мэдээллийн аюулгүй байдал, үйл ажиллагааны цогц байдлыг найдвартай хангах үүднээс Мэдээллийн Аюулгүй Байдлын Удирдлагын Тогтолцоог /МАБУТ/ амжилттай нэвтрүүлж, ISO/IEC 27001:2022 олон улсын стандартын батламжийг хүлээн авлаа.

• ШИНЭ САЛБАРУУД НЭЭГДЛЭЭ


Да Хүрээ болон 22 авто худалдааны төвүүд дээр шинэ салбараа нээж үйл ажиллагаагаа өргөжүүллээ.



Да Хүрээ



22 авто худалдааны төв



• ВЕЕР АПП-ЫГ ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос Финтек зээлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлөө авч

Веер | Мэдэр, БҮТЭЭ, Ялгар! уриатай зээлийн аппликейшнийг зах зээлд амжилттай нэвтрүүллээ.

Веер аппликейшн -ээр цахим зээлийн үйлчилгээ авах, барьцаат зээлийн үйлчилгээний хүсэлтийг илгээх зэрэг боломжууд нэвтэрлээ.



• БАРЬЦААТ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА ОНЛАЙН БОЛЛОО

Түүнчлэн Веер аппликейшнээрээ дамжуулан барьцаат зээлийн өргөдөл, хүсэлтээ зайнаас авч шийдвэрлэх, зээлийн судалгааны Лос системийг нэвтрүүлснээр харилцагчдынхаа цаг зав, зардал мөнгийг хэмнэсэн, хурдан шуурхай үйлчилгээг чиргэдэл багатай хүргээд зогсохгүй, зээлийн шийдвэрийг богино хугацаанд шийдвэрлэж өгөх эхлэл болж байна.

Бүтээгдэхүүн



Финко капитал нь Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр Зээл болон Итгэлцлийн үйлчилгээг эрхэлж байна.

Бид иргэн болон ААНБ-д зориулж Бизнесийн зээл, хэрэглээний зээл, Финтек зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон итгэлцлийн үйлчилгээг санал болгож хүргэж байгаагаас гадна 2024 онд дараах бүтээгдэхүүнүүдийг шинээр гарган тусгайлан төрөлжүүлж харилцагчдад хүргэн үйлчилгээ, хүртээмжээ улам нэмэгдүүлсээр ирлээ.

Үнд:



ЦАЛИНГИЙН
ЗЭЭЛ



ХАНГАН
НИЙЛҮҮЛЭГЧДЭД
ЗОРИУЛСАН ЗЭЭЛ



ХҮҮ ХУВААХ ТУСГАЙ
НӨХЦӨЛТЭЙ БЕТОН
ЗУУРМАГИЙН ЗЭЭЛ

Бүтээгдэхүүн

БЕЕР АППЛИКЕЙШН

ЗЭЭЛ БОЛ БОЛОМЖ.

BEEP is

ON

NOW

БОЛОМЖИЙГ
МЭДЭР!



АВТОМАШИН, УНАДАГ
ДУГУЙ, СКУУТЕР, МОПЕД
ХУДАЛДАН АВАХ НОГООН
ЗЭЭЛ



ХҮНД ДААЦЫН ТЭЭВЭР
ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН
АВАЛТЫН ЗЭЭЛ

Финтек зээлийн чиглэлд бид Веер аппликейшнээр дамжуулан “Онлайн зээл” болон “Ажиллагсдын онлайн зээл” зэрэг бүтээгдэхүүнүүдийг амжилттай нэвтрүүлээд байна.

Эдгээр шийдлүүд нь хэрэглэгчдэд зээлийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, хурдан шуурхай, цаасаар бус дижитал хэлбэрээр авах боломжийг бүрдүүлж, бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлж байна.

Beep

ЭХҮҮН

Хүний нөөц

Ажилтан бүр сэтгэл ханамжтай ажиллах орчныг бүрдүүлэх, урт хугацааны хамтын ажиллагааг хангах, өсөж хөгжих боломжийг олгоход чиглэдэн ажиллаж байна. Энэхүү бодлогын хүрээнд ажилтнуудын ур чадвар, бүтээмжийг дэмжих сургалт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, ажиллах орчин нөхцөл, байгууллагын соёлыг сайжруулах чиглэлээр тогтмол арга хэмжээ авч ажиллаж байна.



Цалин, урамшуулал

Цалин хөлсний судалгааг хийж Монгол улсын эдийн засгийн өсөлт, инфляциас хамааран жил бүр цалин урамшууллыг тодорхой хувиар нэмэгдүүлдэг.



Сургалт, хөгжүүлэлт

Мэргэжлийн болон ерөнхий ур чадварын 13 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 58 ажилтан хамрагдсан.



Ажилтнуудын сэтгэл ханамж

Ажилтны сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд суурь үнэлгээ судалгааг хийж тогтмол сайжруулахад чиглэн ажиллаж байна.



Уян хатан цагийн систем

Ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор уян цагийн системийг амжилттай хэрэгжүүлж байна.

Энэ нь ажилтны ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, ажил, амьдралын тэнцвэрийг хадгалахад дэмжлэг болж байна.

Санхүүгийн тайлан



Аудитын тайлан



ПИ КЭЙ ЭФ АЙ ЭЙ ЭС АУДИТ ХХК
Даян Таун Буюлцанг, #701 тоот,
Жамцалан гүний гудамж -18/1,
1-р хороо, Сүхбаатар дүүрэг-14240,
Улаанбаатар хот, Монгол улс

Имэйл: info@pkf.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ФИНКО КАПИТАЛ БЭСБ" ХХК -ийн төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид "ФИНКО КАПИТАЛ БЭСБ" ХХК (цаашид "Компани" гэх) –ийн 2024 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Санхүүгийн алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйцээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн хураангуй бодлогод аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн санхүүгийн тайлангууд нь компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйцээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлангын Олон Улсын Стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан Монгол банк, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны заавар, журмын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС) –ын дагуу гүйцэтгэлээ. Энэ стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага" хэсэгт тайлбарласан. Бид Монгол улсад мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуу танигддаг ёс зүйн бусад хариуцлага бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохиистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлангын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэх, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэг орно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийн татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохор төлөөлөх байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжтой арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлангын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

"ФИНКО КАПИТАЛ БЭСБ" ХХК -ийн төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдэд

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудыг үндэслэн гаргах хэрэглэгчдийн аргийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

АОУС –ын дагуу хийх аудитын явцад бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Үүнд бид:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэх болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлангын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохиистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхиуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлангын илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлангын илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бичиг хураангуй нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохиистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцолцуулдаг, холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохиистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадмагд мэдэгдэхүйц эргэлтээ үүсгэх болох үйл явцад эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүнлэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайлангаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явцад, нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйцгээ, үйл явцуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын ажлын төлөөлсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр амар нэгэн зорилгоор бичиг, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аргаар нь түрээшлэх тайлан өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Г.Оюунзэрэл
Гүйцэтгэх захирал

Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдөр

ПИ КЭЙ ЭФ АЙ ЭЙ ЭС АУДИТ ХХК
Мэргэцсэн нягтлан бодогчид



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	2023.12.31	2024.12.31
Үзүүлэлт		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,650,525,322.67	1,659,794,553.87
Зээл	3,037,184,047.81	21,168,613,873.95
Бусад санхүүгийн хөрөнгө	68,999,495.76	15,491,689.84
Татвар, НДШ-ийн авлага	-	5,197,275.32
Үндсэн хөрөнгө	153,277,616.35	297,173,132.08
Биет бус хөрөнгө	15,410,352.75	265,589,831.68
Бусад санхүүгийн бус хөрөнгө	-	41,926,359.63
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,925,396,835.34	23,453,786,716.37
Санхүүгийн өр төлбөр	1,349,477,476.18	16,894,582,122.50
Санхүүгийн бус өр төлбөр	-	163,395,066.41
Хувь нийлүүлсэн хөрөнгө	3,555,300,000.00	5,555,300,000.00
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	20,619,359.16	840,509,527.46
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	4,925,396,835.34	23,453,786,716.37

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	2023	2024
Үзүүлэлт		
Хүүгийн орлого	484,114,501.98	3,760,108,504.81
Хүүгийн зардал	-	1,142,095,791.30
Хүүгийн цэвэр орлого	484,114,501.98	2,618,012,713.51
Эрсдэлийн сангийн зардал	-	22,699,447.39
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	484,114,501.98	2,595,313,266.12
Бусад орлого	-	137,287,946.67
Бусад зардал	344,118,661.49	1,816,241,629.54
Татварын өмнөх ашиг, алдагдал	139,995,840.49	916,359,583.25
Орлогын татварын зардал	14,945,020.48	96,469,414.95
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ, АЛДАГДАЛ	125,050,820.01	819,890,168.30

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2023	2024
Үзүүлэлт		
Мөнгөн орлогын дүн	3,939,414,548.90	66,760,338,776.47
Мөнгөн зарлагын дүн	3,591,013,606.52	66,751,069,545.27
БУХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	348,400,942.38	9,269,231.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,302,124,380.29	1,650,525,322.67
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,650,525,322.67	1,659,794,553.87

Эрсдэлийн Удирдлага

ГОЛ ЭРСДЭЛҮҮД	ЭРСДЭЛИЙН ҮЙЛ ЯВДАЛ, ҮР ДАГАВАР, НӨЛӨӨЛӨЛ	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ
ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ	СЗХ-оос ББСБ-уудад тавих хязгаарлалтууд чангарч байна.	Шинээр хэрэгжиж эхэлсэн хууль журмуудтай цаг алдалгүй танилцаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.
САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ	Зохистой харьцааны үзүүлэлт алдагдах. - Төлбөрийн чадвар алдагдах буюу хөрөнгө оруулагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар буцаан төлөх боломжгүй болох. - Зээлийн эрэлт, өсөлтийг хангахгүй болох. - Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа үзүүлэлт алдагдах	- Төлөвлөлт хангалттай хэрэгжүүлэн ажиллаж байна. - Сар бүр дотоодын тогтмол тайлагналт хийж байгаа. - Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн. - Эх үүсвэрийн төвлөрлийг удирдсан. - Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулсан бодлого чиглэл баримталж ажиллаж байна.
ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ	- Зээлийн багцын чанар буурах. - Зээлийн эргэн төлөлтүүд тасалдах - Зээлийн эрсдлийн сангийн хэмжээ өсөх	Зээл судалгааны процессийг автоматжуулж, скорингийг чангалж өглөө. Цаашдаа зээлийн эргэн төлөлтийг харилцагч талд хялбар байлгах үүднээс автоматжуулалтын ажлууд хийгдэж ажиллах төлөвлөгөөтэй байна.
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ	Одоо ашиглаж буй системүүд бүрэн автомат биш, хүнээс хамаарсан доголдлууд гарах эрсдэлтэй байна	Бид өөрсдийн гэсэн дотоодын үйл ажиллагааны програм хангамжийг бий болгон, сайжруулалт хийн ажиллаж байна.
МАБ-ЫН ЭРСДЭЛ	- Мэдээлэл алдагдах, түүнийг буруугаар ашиглах. - Мэдээллийн бааз гэмтэх, устах. мэдээлэлд хандах боломжгүй болох. - Системийн эмзэг байдлыг ашиглах	- Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлж, түүнтэй холбоотой журмуудыг шинэчлэн баталлаа. - Системийн эмзэг байдал, цахим халдлага зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлж тогтмол аюулгүй байдлын тест явуулж, тасралтгүй сайжруулалтыг хийж ажилалаа.



Засаглал



Финко Капитал ББСБ ХХК ("Компани")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийнхаа засаглалын бүтцийг Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэх, Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, нөөц, дотоод хяналт, эрсдэлийг зөв зохистой удирдах, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг эрмэлзэн ажилладаг.

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс зарчмуудыг баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд сайн засаглал нь бизнесийн стратегийг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хувьцаа эзэмшигчид болон харилцагч, бусад оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах, ёс зүйтэй, шударга байдлыг ханган ажиллахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үздэг.



ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

Компани нь компанийн засаглалын стандартыг баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийн төлөө хүчин чармайлт гарган ажилладаг бөгөөд сайн засаглал нь бизнесийн стратегийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үздэг.

Компани нь компанийн засаглалын тулгуур дөрвөн зарчим болох хариуцлагатай, ил тод, шударга байдал, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэсэн, сайн засаглалын туршлагад тулгуурласан засаглалын бүтцийг бүрдүүлээд байна. Энэ нь Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн, Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, дотоод хяналт, эрсдэлийг зөв зохистой удирдах, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн засаглалын бүтэц юм.



● Томилох, чөлөөлөх

● Тайлагнах, мэдээлэх

ТУЗ-ын бүрэлдэхүүн



Гансүхийн Бат-Эрдэнэ нь Финко Капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан захирал, Премиум Иннова ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан захирлаар ажилладаг.

Тэрээр анхны ажлын гараагаа үйлдвэрлэл, худалдааны салбарт тэргүүлэгч М-Си-Эс Кока Кола ХХК-д санхүү төлөвлөлтийн газрын даргаар эхлүүлж байв. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэрлэл, барилгын салбарт ажиллаж, Монголиан Майнинг Корпораци (НКЕХ: 975) болон Премиум Групп ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан бөгөөд М-Си-Эс Энержи ХХК-ийн дэд захирал, Монголиан Майнинг Корпорацийн Санхүү хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Г.Бат-Эрдэнэ нь Хан-Уул Дээд Сургуулийг бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

Г.БАТ-ЭРДЭНЭ

ТУЗ-ын дарга



Нямжавын Энхболд нь Финко Капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн бөгөөд 2016 оноос Ньюком Группийн Гүйцэтгэх захирлаар, 2017 оноос 2022 оныг хүртэл ТУЗ-ийн даргаар ажиллаж тус группийн өсөлтийг тасралтгүй хангах, үнэ цэнийг бий болгохын тулд гүйцэтгэх удирдлагын багтай хамтран ажилласан.

Тэрээр хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлага, санхүү, төсөл боловсруулалт, корпорацийн стратеги, бизнес хөгжил, үйл ажиллагаа зэрэг Ньюкомын бүхий л салбар нэгжид идэвхтэй үүрэг гүйцэтгэн ажилласан бөгөөд тус группийн хөрөнгө оруулалттай компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар мөн ажиллаж байсан.

Тэрээр өмнө нь М-Си-Эс Группийн стратеги, бизнес хөгжил хариуцсан дэд захирал, группийн бусад компаниудад гүйцэтгэх удирдлагаар 17 жил ажиллахдаа мэдээллийн технологи, харилцаа холбоо, санхүү, үл хөдлөх хөрөнгө зэрэг олон салбарт ажилласан туршлагатай. Н.Энхболд нь Нидерландын Маастрихтын Удирдлагын Сургуулийг корпорацийн стратеги, бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй, МУИС-ийг электроникийн инженер, бакалаврын зэрэгтэй төгссөн.

Н.ЭНХБОЛД
ТУЗ-ын гишүүн



Батболдын Ганзориг нь Финко Капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-н гишүүн бөгөөд Премиум Иннова ХХК-ийн Коммерс хариуцсан захирлаар ажилладаг.

Тэрээр өмнө нь тус компанийн Гүйцэтгэх захирлын туслах, Тасралтгүй боловсрол судалгааны институт-ыг хамтран үүсгэн байгуулагч, Централ Экспресс Си Ви Эс ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн менежер, Cloud BI ХХК-д BI хөгжүүлэгч, Санхүү эдийн засгийн их сургууль-д багшилж байсан.

Б.Ганзориг нь Санхүү эдийн засгийн их сургуулийг Санхүүгийн удирдлагын бакалавр, Бизнесийн удирдлагын магистр, Тайван-ийн Asia University-д санхүүгийн чиглэлээр бакалаврын зэрэг дүүргэсэн. Түүнчлэн тэрээр CFA цолтой, FRM (Financial Risk Manager) хөтөлбөрийн I түвшинг дүүргэсэн.

Б.ГАНЗОРИГ, CFA
ТУЗ-ын гишүүн



Лхагвасүрэнгийн Цолмон нь Финко Капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирлаар ажилладаг.

Тэрээр өмнө нь Төв Азийн Зам ХХК-ийн Санхүү хариуцсан захирал, М-Си-Эс Кока Кола ХХК-ийн санхүү хариуцсан захирал, М-Си-Эс Холдинг-д Хөрөнгө оруулалтын менежер, Хөрөнгө оруулалтын ахлах шинжээч, Их Британи Улсын Лондон хотод төвтэй Тайгэр Менежмент Групп-д ахлах нягтлан бодогч, Сангийн Яамны Төрийн сангийн газар мэргэжилтэнээр тус тус ажиллаж байсан.

Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр 23 жилийн туршлагатай, олон улсын болон дотоодын тэргүүлэгч байгууллагуудад ажиллаж, санхүү, үйл ажиллагааны менежмент, хөрөнгө оруулалтын хэлцэл, стратеги төлөвлөлтийн чиглэлээр амжилттай ажиллаж олон сая ам.долларын хөрөнгө оруулалт, нэгдэл, худалдан авалтын хэлцлүүдэд голлох үүрэгтэй оролцож, М-Си-Эс группийн олон охин компанийн стратеги, санхүүгийн гүйцэтгэлийг удирдан чиглүүлж байв. Мөн MCS-ийн охин компаниудад зориулан дотоод, олон улсын хөрөнгө оруулагчидтай харилцаа тогтоож, нийт 300 сая ам.долларын санхүүжилтийг татах багийн гишүүнээр ажилласан.

Л.Цолмон нь Монгол Улсын Их Сургуулийг Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн чиглэлээр, Английн Англия Раскин Их Сургуулийг Олон улсын бизнесийн магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн.

Л.ЦОЛМОН

ТУЗ-ын гишүүн



Баяраагийн Баяртбилэг нь Финко Капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, уул уурхайн хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Говь Вентур ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тэрээр өмнө нь Голомт банкны Корпорацийн зээлийн хэлтсийн захирал, Эрсдэлийн ахлах менежер, Төслийн зээлийн ажилтан, мөн Лондон хотод төвтэй Blocks Smartwatch компанид санхүүгийн албаны даргаар тус тус ажиллаж байсан.

Тэрээр Уул уурхайн төсөлд зориулан 10+ сая ам.долларын хөрөнгө босгож, хайгуул, судалгаа, зөвшөөрлийн процессыг удирдан ажиллаж байсан. Зээлийн процессыг бүхэлд нь шинэчилж, зээлийн онооны системийг нэвтрүүлсэн бөгөөд зээл олголтоос эхлээд эргэн төлөлт, төлбөрийн хяналт хүртэлх бүхий л үе шатны үйл ажиллагааг дахин зохион байгуулсан. Мөн зээлийн ажилтнуудад зориулсан цогц сургалтын системийг бий болгосон байна.

Б.Баяртбилэг нь Империа Коллежийн Бизнесийн сургуулийг Хөрөнгө оруулалт ба хөрөнгийн удирдлагын чиглэлээр магистр зэрэгтэй, МУИС-ийг Олон улсын эдийн засгийн харилцааны магистр, Хан-Уул дээд сургуулийг хэрэглээний математикийн мэргэжлээр бакалавр зэрэгтэйгээр тус тус төгссөн.

Б.БАЯРТБИЛЭГ

ТУЗ-ын хараат бус гишүүн



Баатарын Мөнхбат нь Финко Капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, 2020 оноос хойш NubiSoft ХХК-ийг үүсгэн байгуулж, гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа бөгөөд Голомт банкны Мэдээллийн технологийн газрын хэлтсийн захирал, IT төслийн менежер, системийн шинжээч, программын инженер зэрэг албан тушаалуудад ажиллаж байсан туршлагатай.

Голомт банкны үндсэн бүртгэлийн системийн нэвтрүүлэлт, Finacle corebanking систем, интернет банк, мобайл банк, AML систем зэрэг томоохон мэдээллийн технологийн шийдлүүдийг амжилттай хэрэгжүүлж, банкны дотоод процесс, системийн интеграцчилал, чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж ирсэн.

Тэрээр Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбооны гишүүнээр ажиллаж, салбарын хөгжилд хувь нэмрээ оруулсаар байна. Мөн PMI-ACP, Oracle Developer OCP, COBIT Foundation зэрэг олон улсын мэргэшлийн сургалтуудыг дүүргэсэн бөгөөд стратеги төлөвлөлт, бизнес процессын анализ, системийн архитекторчлал, чанарын менежмент, өөрчлөлтийн удирдлага зэрэг чиглэлээр гүнзгий мэдлэг, практик туршлагатай.

Б.Мөнхбат нь ШУТИС-н КТМС-ийг Програм хангамжийн инженер мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, мөн Компьютерийн ухааны чиглэлээр магистрын зэрэгтэйгээр төгссөн.

Б.МӨНХБАТ

ТУЗ-ын хараат бус гишүүн



Хувьцаа эзэмшигчдийн хурал



Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хууль болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Компанийн хувьцаа эзэмшигчид нь нийт 4 асуудлыг хэлэлцэн шийдвэрлээд байна. 2024 оны 01-р сарын 22-ны өдрийн 1 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийг 6 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр баталж ТУЗ-ийн ердийн гишүүдээр Г.Бат-Эрдэнэ, Л.Цолмон, Н.Энхболд, Б.Ганзориг нарыг, хараат бус гишүүдээр Б.Мөнхбат, Б.Баяртбилэг нарыг тус тус томилох, 08-р сарын 15-ны өдрийн 2 тоот тогтоолоор гурван тэрбум төгрөгийн бондын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 12-р сарын 19-ний өдрийн 3 тоот тогтоолоор Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хоёр тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, 4 тоот тогтоолоор Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлээд байна.

НОГДОЛ АШИГ БА СОНИРХЛЫН

ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Компани нь Компанийн 2024 оны санхүүгийн жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаагүй бөгөөд тайлант хугацаанд холбоотой тал буюу Премиум Нэксус ХК болон түүний охин компаниудын ханган нийлүүлэгчдэд зээлийн үйлчилгээ үзүүлэх сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ нь Компанид урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлж, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлж ажилладаг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 01-р сарын 19-ний өдрийн 1 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнийг 6 гишүүний бүрэлдэхүүнтэй болгохоор шийдвэрлэсэн бөгөөд эдгээр гишүүдийн 4 нь ердийн, 2 нь хараат бус гишүүд бөгөөд ТУЗ-ийн 2024 оны 02-р сарын 01-ний өдрийн 1 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар Г.Бат-Эрдэнэ-г сонгож, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Т.Гантулга-г томилсон.

ТУЗ болон ТУЗ-ийн хороодын бүтэц

ТУЗ	Аудитын хороо	Нэр дэвшүүлэх хороо	Цалин урамшууллын хороо
Дарга Г.Бат-Эрдэнэ	Дарга Б.Мөнхбат	Дарга Б.Мөнхбат	Гишүүн Б.Баяртбилэг
Гишүүн Л.Цолмон	Дарга Б.Баяртбилэг	Гишүүн Л.Цолмон	Гишүүн Г.Бат-Эрдэнэ
Гишүүн Н.Энхболд	Гишүүн Г.Бат-Эрдэнэ	Гишүүн Н.Энхболд	Гишүүн Б.Ганзориг
Гишүүн Б.Ганзориг			
Хараат бус гишүүн Б.Мөнхбат			
Хараат бус гишүүн Б.Баяртбилэг			

2024 онд ТУЗ нь жилийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төсөв батлах, зээл авах, салбар нэгжүүдийг байгуулах, цахим зээлийн үйлчилгээ нэвтрүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, урт, богино хугацааны урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмуудыг батлан, хэрэгжүүлэх, цалин хөлс тогтоох аргачлалыг тодорхойлох зэрэг нийт 11 асуудлуудыг хэлэлцэн баталсан байна.




КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭ


Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03-р сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан Компанийн засаглалын кодексийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, хэрэгжүүлэхээр чармайн ажилласан бөгөөд Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээний үр дүн Компанийн өөрийн үнэлгээгээр 90 хувь буюу хэвийн засаглалтай байсан байна.

2024 оны засаглалын үнэлгээ

Нэгдсэн үнэлгээний агуулга	Авбал зохих оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11	92%
ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90%
Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%
Эрсдэлийн удирдлага	8	6	75%
Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
Компанийн соёл	6	4	67%
Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
Нэгдсэн дүн	72	65	90%

Байгууллагын бүтэц











Дэлгэрэнгүйг: 7717-3311

Төв салбар: 8888-6740, 8801-1446

СБД, 1-р хороо, Олимпийн гудамж, Олимпик Галлериа, 4-408 тоот

Даваа-Баасан 09:00-18:00 цаг

Сакура салбар: 8888-6720, 8810-4483

БЗД, 26-р хороо, Сакура оффис 8-811 тоот

Даваа-Баасан 09:00-18:00 цаг

Да хүрээ салбар: 8888-6710

БЗД, 17-р хороо, Даймонд худалдааны төв, 59а байр 29 тоот

Даваа, Ням гарагаас бусад өдрүүдэд 10:00-18:00 цаг

22-ын товчооны салбар: 8071-9595

СХД, 32-р хороо, Авто худалдааны төв, Автоком төв, А блок, 3-302 тоот

Мягмар гарагаас бусад өдрүүдэд 10:00-18:00 цаг

www.Finco.mn

f Finco Capital NBF

Веер апп татах

